

ӨГҮҮЛЭЛ

Монголч эрдэмтэн Н.П.Шастина

Ю.В.Кузьмин*

*Профессор, доктор Sc.D, Байгалын их сургууль, Эрхүү, ОХУ
kuzminuv@yandex.ru*

Хэрээд Жамсрангийн Урангуа

*Профессор, доктор Sc.D, Монгол Улсын их сургууль, Улаанбаатар, Монгол Улс
urangua@num.edu.mn*

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Зөвлөлт Холбоот Улсын нэрт судлаач Н.П.Шастина (1898-1980)-гийн Монгол судлалын бүтээлүүдийн үзэл санаа болон бүтээл туурвилын товч намтрыг нь дэлгэн тавьж байна. Чингэхдээ Н.П.Шастинагийн Оросын монгол судлалын түүх, тус орны тэргүүлэх монголч эрдэмтдийн намтар судлалд зориулсан бүтээлүүдэд гол анхаарлаа хандуулав. Мөн түүнчлэн Н.П.Шастинагаас XIX зууны Оросын Монгол судлал болон Оросын шинжлэх ухааны түүхийг судлахад оруулсан хувь нэмрийг цохон тэмдэглэсэн болно.

Түлхүүр үгс: Н.П.Шастина, Оросын Монгол судлал, түүх бичлэг, шинжлэх ухааны түүх, бүтээлч намтар

Орчин үеийн Дэлхийн Монгол судлалд Оросын Монгол судлалын түүх чухал байр суурь эзэлдэг билээ. Оросын монголч эрдэмтэд болох М.И.Гольман, Д.Б.Улымжиев, Ш.Б.Чимитдоржиев, В.Э.Раднаев, А.Н.Хохлов, С.Г.Кляшторный, Г.Ф.Шамов, В.Д.Дугаров,

И.В.Кульганек, Н.П.Шастина, О.Н.Полянская, К.Н.Яцковская нар эл салбарт томоохон хувь нэмэр оруулсан юм. Эдгээр судлаачдын дундаас 1960-1980 оны хоорондох Зөвлөлтийн Монгол судлалыг үлэмж хөгжүүлсэн Нина Павловна Шастина (1898-1980 он) онцгой

* Холбоо барих зохиогч



байр суурь эзэлнэ. Түүний бүтээл туурвилын наяд хувь нь XIX зууны үеийн Монгол судлалд зориулагдсан байна. Тухайлбал: Оросын нэрт Монгол судлаач Н.Я.Бичурин, О.М.Ковалевский, Д.Банзаров, В.П.Васильев, А.М.Позднеев, Б.Я.Владимирцов нарын бүтээлч намтар, тэдний шинжлэх ухааны өв судлалд зориулагджээ.¹

Орчин үеийн түүх бичлэгт Н.П.Шастинагийн бүтээл туурвилын судлал бүрэн дүүрэн тусгагдаагүй байна. Нина Павловна Шастинагийн талаар К.Н.Яцковский, Ю.В.Кузьмин, С.Д.Милибанд нарын өгүүлүүдэд бичигдсэн зүйлс нь ямар нэгэн тэмдэглэлт ойд зориулагдсан эсвэл лавлагааны шинжтэй нийтлэлүүд байдаг бөгөөд уг судлаачийн бүтээл туурвил, тэдгээрийн үзэл санаа бүрэн дүүрэн тусгагдаагүй байгаа нь ажиглагдана.²

Н.П.Шастина Оросын монгол судлалын түүхийн талаар докторын диссертаци хийхээр төлөвлөж байсан нь мэдэгдэж байгаа³ бөгөөд энэ сэдвээр хэвлэгдсэн нийтлэлүүд нь энэхүү асуудлыг тууштай, системтэй судалж байсныг гэрчилж

байна. Н.П.Шастинагийн бүтээлүүд нь нэн өвөрмөц шинж чанартай бөгөөд өнөө үед ч шинжлэх ухааны ач холбогдлоо алдаагүй байна. Тэрээр Оросын алдарт Монголч эрдэмтдийн сонирхолтой шинж чанарууд, ялангуяа Монгол судлал дахь Орос, Германы дэг сургуулиудын хоорондын харилцааны үнэлгээ өгсөн хийгээд анхны маргаантай асуудлууд зэргийг багтаасан, Оросын Монгол судлалын эхэн үеийн үе шат, монгол судлаачдын хоорондын шинжлэх ухааны харилцааны мөн чанар болон тэдгээрийн судалгааны залгамж холбоог илэрхийлсэн байдаг нь түүний бүтээлүүдийн үнэ цэнийг тодорхойлдог юм.

Монгол Улсад Н.П.Шастинагийн мэндэлсний 75 жилийн ойг тохиолдуулан академич Д.Цэрэнсодном Үнэн сонинд “Нина Павловна Шастина” гэх нийтлэл хэвлүүлжээ. Түүнд, Цэрэнсодном Шастиантай Москвад уулзаж ярилцсан тэмдэглэл дээрээ үндэслэн түүний бүтээл туурвилын тухай өгүүлсэн байдаг.

Энэхүү өгүүлийг тэрлэгч Ю.В.Кузьмин 2004 онд “Эрхүүгийн Монгол судлал: 1725-2004 он,

- 1 Шастина Н.П. Значение трудов Н.Я.Бичурина // Очерки по истории русского востоковедения. – М., 1956. – С.182; Шастина Н.П. Эпиграфика в работах Доржи Банзарова // К столетию со дня смерти Доржи Банзарова.- Улан-Удэ, 1955. – С.51; Шастина Н.П. А.М.Позднеев. Подготовка к печати, примечания. А.Г.Сазыкина //Mongolica – 6. – СПб, 2003. – С.7-18; Шастина Н.П. Перевод И.Рассохина по истории монголов конца ХУП в. – Ученые записки Института Востоковедения (АН СССР). Том 6, М.-Л.,1953. –С.200-211; Шастина Н.П. Из переписки О.М.Ковалевского с бурятскими друзьями. – В кн.: Материалы по истории и филологии Центральной Азии. – Улан-Удэ.
- 2 Кузьмин Ю.В. 95-летие со дня рождения Н.П.Шастиной// Billetin International Association for Mongol Studies. –Ulaanbaatar, 1993. -№2(12). – С.89; Кузьмин Ю.В. Нина Павловна Шастина – исследовательница Монголии //Тальцы. – Иркутск, 2002. №1(13). – С.22-26; Яцковская К.Н. Неопубликованные материалы 20-х годов из личного архива Н.П.Шастиной (1898-1980) // Mongolika - III. Из архивов отечественных монголоведов XIX - начало XX вв.- Санкт-Петербург, 1994.-С.23-25.
- 3 Кузьмин Ю.В. Монголоведные исследования Н.П.Шастиной// Россия и Восток: взгляд из Сибири на нач. тыс. Материалы межд.конф. –Иркутск, 2002. – С.135-139.

судлаачид ба тэдний бүтээлүүд” гэх номдоо Н.П.Шастинагийн эрдэм судлалын ажлын талаар оруулан юм. Мөн түүхч Ж.Урангуа 2015 онд “Дэлхийн Монгол судлал” номын 2 дугаар ботид Нина Павловна Шастины товч намтар, Монгол судлалын гол гол бүтээлүүдийн талаар товч мэдээлэл өгсөн амуй.

2008 онд Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан монголч эрдэмтдийн судалгааны өгүүллүүдийн түүвэрт Н.П.Шастинагийн “Монгол бичгийн дурсгал дахь Гэсэр хааны домог” гэх өгүүлэл нь орсон байна.

Н.П.Шастинагийн мэндэлсний 110 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал Эрхүүгийн Улсын Багшийн Их Сургууль дээр 2008 онд болж, эрдэмтэн судлаачид Шастинагийн Монгол судлалын өвийн талаар илтгэлүүд тавьсан байна.

Нина Павловна 1898 онд Эрхүү хотод төрсөн. Түүний эцэг Павел Николаевич Шастин эмч Монголд 14 жил амжилттай ажиллаж, тус улсад орчин үеийн анагаах ухааны тогтолцоог бий болгосон гавьяатай хүн юм. Шастиныхан Монголд дөрвөн үеэрээ ирж ажиллаж байсан байна. Анх өвөг эцэг Николай Петрович Шастин Халхын Их Хүрээнд 1864 онд ирж, Хаант Оросын консулын Үнэн алдартны сүмийн миссионер байжээ. Тэрээр 1980 онд Казаны шашны Академийн шашин номлогч нарыг бэлтгэх ангид монгол хэлний ангид суралцаж төгссөн нэгэн байв. Нинагийн эцэг П.Н.Шастин нь Казаны

их сургуулийн анагаах ухааны анги төгссөн бөгөөд 1923 онд Монголын урилгаар ирж ажиллахдаа цэргийн эмчээр ирсэн боловч дараа нь иргэний эмчээр олон жил ажилласан, монголчуудын эрүүл мэндийн төлөө цаг наргүй ажиллаж, олон түмний дунд их нэр хүндтэй эмч байсан юм. Шастин докторын монголчуудын төлөө ажилласан хөдөлмөрийг нь үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж, 1961 онд Нийслэлийн III эмнэлгийг П.Н.Шастины нэрэмжит болгосон юм. Түүний хүү Николай Павлович Шастин гэр бүлийнхээ хамт 1926 онд Монголд ирж 9 жил ажилласан, эхнэр Тамара Николаевна Яценко нь Сонгино дахь тахлын лабораторид нян судлаач эмчээр ажиллаж байсан бөгөөд тус улсын анхны лабораторийг үүсгэн байгуулсан байдаг. Ач хүү Павел Николаевич Шастин Монголд төрж, өвөг эцэг болон аавынхаа мэргэжлийг залгамжлан эмч болж, 1965-1974 онуудад Улаанбаатар хотын хүүхдийн эмнэлэгт мэс заслын эмчээр ажилласан байна. Түүнийг Улсын Их Хурлын зарлигаар “Найрамдал” медалиар шагнасан байдаг. Ийнхүү Шастины гэр бүлийнхэн Монгол оронтой ажил, амьдралаараа холбогдсон гэр бүл байв.

Нина 1923 онд Эрхүүгийн Улсын их сургуулийг онц дүнтэй төгссөн, улмаар 1924 онд Монголд аав дээрээ ирж Монголд нийт 13 жил амьдрахдаа анхлан Мал эмнэлгийн газар ажиллаж байгаад дараа нь 1929 оноос⁴ Монгол улсын шинжлэх ухааны анхны байгууллага болох Судар бичгийн

4 УТА, Ф-23, д.1, хн 303, хуудас 1-8 Анкет,1632 он

хүрээлэнд ажиллах болсон ба 1931 оноос⁵ тус байгууллагын Номын сангийн Европ ном сэтгүүлийн тасгийн эрхлэгчээр ажиллаж байжээ.

1924 онд Судар бичгийн хүрээлэн Эрхлэх үйлдвэрийн товчоо хэмээх зорилтод хөтөлбөрийг баталж, ЗХУ-ын Засгийн газрын дэргэд 1925 онд байгуулагдсан “Монголын комисс” Монголд шинжлэх ухааны олон салбарын экспедицүүдийг Судар бичгийн хүрээлэн дээр түшиглэн ажиллуулж байв. ЗХУ-аас В.И.Лисовский, В.А.Казакевич, С.А.Кондратьев, Б.Ф.Смирнов нар Монголд байнга амьдран Судар бичгийн хүрээлэнд алба хааж байсан бөгөөд тус хүрээлэнгийн ажилд нэлээдгүй хувь нэмэр оруулжээ. 1929 онд номын сан, музей, Төвөд эмнэлгийн тасаг, дуу хөгжмийн тасаг, газрын зургийн тасаг, гэрэл зургийн тасаг, лаборатори, дуун ухааны тасаг, түүхийн тасаг, архив гэсэн тасаг, салбаруудтай болж өргөжсөн бөгөөд Судар бичгийн хүрээлэн нь 1930 онд Шинжлэх ухааны хүрээлэн болон өргөжсөн юм.

Монгол Улсын үндэсний төв архивд хадгалагдаж буй Шинжлэх ухааны хүрээлэнгийн баримтуудад Н.П.Шастинагийн анкет хадгалагдаж байна. Түүнд тэмдэглэснээр, Нина Павловна англи болон франц хэл мэднэ, тус газар номын сангийн европ сангийн эрхлэгч, нам эвлэлийн гишүүн бус, дээд сургууль төгссөн. Номын санд ажиллахаас өмнө Мал эмнэлгийн газар ажиллаж байсан,

31 настай, хүүхэдгүй, ард гаралтай, орос гаралтай, Орос улсын харьяат гэсэн байх бөгөөд эрхлэх хүмүүсийн санал гэсэн буюу удирдлагын үнэлгээнд “идэвх оролдлоготой”⁶ хэмээн тодорхойлжээ. Үнэхээр ч Н.П.Шастина идэвх зүтгэлтэй ажиллаж тус хүрээлэнгийн номын санг орчин үеийн номын сан болгоход ихээхэн ажил хийснийг архивын баримтууд нотолж байна. Судар бичгийн хүрээлэнгийн баримтууд дунд Шастина боловсруулан, эрдэмтэн нарийн бичгийн дарга Тубянскийгаар батлуулсан 1932,1933 оны ажлын төлөвлөгөө хадгалагдаж байна⁷. Тэдгээрээс харахад европ ном, сэтгүүлийг системчлэн каталогжуулах, Монгол судлалын ном сэтгүүлүүдийн номзүй хийх, гадаадаас ном зохиолууд захиалах, хувь хүмүүсийн гар дээрээс ном судар худалдан авах, байр сав агуулгын асуудлыг шийдэх гэх мэт олон ажлыг санаачлан хийж байжээ.

Ийнхүү Шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сангийн Европ номыг хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байхдаа тус хүрээлэнгийн нарийн бичгийн дарга Тубянский, Ц.Ж.Жамцарано, П.К.Козлов, Н.К.Рерих, Ю.Н.Рерих, В.И.Лисовский, А.Д.Симуков, С.А.Кондратьев зэрэг эрдэмтэдтэй ойр дотно ажиллаж байсан нь түүнд монгол судлалын талбарын том сургууль болжээ.

Монголд ирснийхээ хойтон жил “Бүсгүйчүүлийн санал” сэтгүүлийн 1925 оны хоёрдугаарт “Бүсгүйчүүд юуны учир эрчүүдээс дорой болсон

5 УТА, Ф-23, д.1, хн 243, хуудас 3-7 Анкет,1929 он

6 УТА, Ф-23, д.1, хн 243, хуудас 3-7 Анкет,1929 он

7 УТА, Ф-23, д.1, хн 312. Н.П.Шастинагийн ажлын төлөвлөгөө 1932,1933 он

тухай” гэх нэгэн нийтлэл хэвлүүлсэн гэж доктор Л.Энхбаатар дурджээ⁸. Н.П.Шастина Эрхүүгийн их сургуульд сурч байхдаа шашны түүх ихээхэн сонирхож байсан ба Монголд ажиллаж байхдаа буддын шашин, архитектур, монгол цам, эртний монгол болон төвөд ном зохиол ихээхэн сонирхох болжээ. Монголд ажиллаж амьдарч байсан болохоор түүнд монгол хэл сурах явдал дөхөм байв. Түүнээс гадна 1931 оноос эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах болсон нь түүний эрдэм судлалын болон орчуулга, судалгаа шинжилгээний ажлын гараа нь болсон гэлтэй. Тэр үед Шинжлэх ухааны хүрээлэнд Монголын сор болсон бичиг номын хүмүүс ажиллаж байсан бөгөөд тэдэнд Нина Павловна шавь орж худам монгол бичиг төгс эзэмших үүд хаалга нь нээгджээ. Судар бичгийн хүрээлэнгийн хүрээлэнд төвд хэл бичиг сайн эзэмшсэн Шагж, Бат Очир нар болон номч лам гавж Зава Дамдин, Гэлэгжамц дооромбо, гавж Далай зэрэг хүмүүс ажиллаж байсан учир Нина Павловна тэдний хэн нэгэнд шавь орж төвөд хэл сурсан байх хэмээн төсөөлөгдөнө.

Хатагтай Шастинагийн хүсэл тэмүүлэл, чадвар, чин сэтгэл нь түүнийг сайн Монгол судлаач болоход нь хүргэсэн хүчин зүйлс амуй. Нина их сургуульд сурч байхдаа хүмүүнлэгийн сонгодог боловсрол

эзэмшсэн, европын хэд хэдэн хэл сайн мэддэг болсон нь Судар бичгийн хүрээлэнд ажиллаж байхдаа Европ зүгийн ном зохиолыг орчуулах ажлын хийж гүйцэтгэхэд нь ихээхэн дөхөм болж байсан нь дамжиггүй. Тиймээс ч тэрээр Европын алдарт монгол судлаачдын бүтээлийг орос хэл дээр орчуулах ажил хийж эхэлсэн агаад анхныхан Д.Оссоны номыг франц хэлнээс орчуулах чиглэлээр ажиллажээ. Н.П.Шастина анхны нийтлэлүүдээ “Монголын аж ахуй”, “Орчин үеийн Монгол” сэтгүүлүүдэд хэвлүүлжээ. Тэрээр монголын шашны баяр ёслол, зан үйлийн талаарх судалгаа болсон “Цам” өгүүлэл 1928 онд, мөн онд “Цогчин баярын өдрүүдэд” гэх өгүүлэл, 1935 онд “Зүүн Хүрээний хийд дэх шашны нууц-”Цам”, “Майдар эргэлт” зэргийг хэвлүүлжээ⁹. Эдгээр бүтээлүүд нь Монголын Буддын шашны сүмийг устгах үеэр хэвлэгдсэн тул түүхийн шинжлэх ухаанд онцгой ач холбогдолтой юм.

1936 онд Зөвлөлтийн олон мэргэжилтнүүдийн нэгэн адил Шастины гэр бүлийнхэн эх орондоо буцжээ. Н.П.Шастина 1937-1942 онд Ленинград хотод Шинжлэх ухааны академийн номын сан, ЗСБНХУ-ын Шинжлэх ухааны академийн Угсаатны зүйн хүрээлэнгийн номын санд ажиллаж, Монгол судлалаар үргэлжлүүлэн ажиллаж байв. Дэлхийн хоёрдугаар дайны үеэр тэрээр

8 Л.Энхбаатар. Дөрвөн үеэрээ Монголд зүтгэсэн орос эмчийн гэр бүл. https://www.tolgoilogch.mn/_vh-vkhsz88

9 Шастина Н.П. «ЦАМ» (праздник в ламайских монастырях Монголии). – Хозяйство Монголии, 1928, №4(11). – С.79-83; Шастина Н.П. Цохчин в праздничные дни. – Хозяйство Монголии, 1928, №4(11). – С.79-83; Шастина Н.П. Религиозная мистерия “цам” в монастыре Дзун-хуре // Современная Монголия, 1935, № 1. №4(11); Шастина Н.П. Круговращение Майдари. – Современная Монголия, 1935, №5. С.106-107.

Ленинградын бүслэлтэд байсан бөгөөд Шинжлэх ухааны академийн номын сан, Угсаатны зүйн хүрээлэнгийн номын санд 1942 оны 5 дугаар сарын 7 хүртэл ажиллаж байгаад Сибирьд ирж 1945 он хүртэл Эрхүүгийн их сургуульд багшилжээ. Улмаар 1950 онд Ленинградд “Первые сношения Московского государства с Алтын ханами Западной Монголии” гэсэн сэдэвт судалгааны ажлаар дэд докторын зэрэг хамгаалж, дараа нь ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнд 1978 он хүртэл үр бүтээлтэй ажилласан байна.

Нина Павловнагийн шинжлэх ухааны сонирхлын хүрээ нь түүний бүтээлч намгарт нэлээд тогтвортой байна. Тэдгээр нь Буддын сүм хийдийн түүх, Орос-Монголын харилцааны түүхийн эхэн үе, монголын түүх бичлэгийн уламжлал зэрэг байжээ. Н.П.Шастинагийн судалгаанд монгол сурвалж бичиг, түүх судлалын асуудлууд хамгийн чухал бөгөөд гол байр суурийг эзэлж байжээ. Монголын түүхийн эх сурвалжууд, түүний тексийн судалгаа нь судлаачаар мэдлэг, чадвар, тэвчээр шаардсан ажил байлаа. Тэрээр гурван том сурвалж судалсан бөгөөд түүний хоёр нь хэвлэгдэн гарч, нийтийн хүртээл болсон юм. Тэрээр Монголын түүх бичлэгийн томоохон дурсгал болох “Шар тууж” (1957), Лувсанданзангийн “Алтан товч” (1973) зэргийг сурвалж судлалын үүднээс судалж, мөн “XVII зууны Орос-

Монголын элчийн харилцаа” (1958) нэгэн сэдэвт зохиол гэх мэт суурь судалгааны бүтээлүүдийг туурвижээ¹⁰. Энэ бол Монгол судлалд тохиолдсон ховор тохиолдол, ихэвчлэн эрдэмтэн нэг түүхэн сурвалж бичгийг хэвлэлд бэлтгэж чаддаг бол Нина Павловна хоёр том эх сурвалжийг бүрэн судалж хэвлүүлэн мөн, нэгийг нь хэвлүүлэхэд бэлтгэж чаджээ¹¹. Үүний цаана нөр их хөдөлмөр оршино. Эх сурвалжийг орчуулан хэвлэлд бэлтгэхэд монгол текстийг уншиж ухварлах, эх сурвалжийн янз бүрийн хэвлэлийг харьцуулах, тэмдэглэл бэлтгэх, дэлгэрэнгүй тайлбар бичих гэх мэтэд мэдээж олон жилийн уйгагүй эрдэм шинжилгээний хөдөлмөр, цаг хугацаа шаардагдана.

Нина Павловна “Дундад зууны монголчуудын уран зохиол дахь Чингис хааны дүр” өгүүлэлд (1970, 1977)¹² Монголын XIII зуун болон XVII зууны хоёр том сурвалжид харьцуулсан судалгаа хийсэн нь хилийн чанад дахь Монгол судлалд өнөө хэр хэн ч хийгээгүй харьцуулсан судалгааг хийж чадсан юм. Өөрөөр хэлбэл, тэрээр Монголын дундад үеийн хоёр гайхамшигт түүхэн хоёр эх сурвалжийг Өрнөдөд шинжлэх ухааны эргэлтэд оруулсан юм. Нийтлэлийн түүврийг нэрт, мэргэжлийн дорно дахин судлаачид С.Л.Тихвинский, Э.И.Кычанов, И.П.Петрушевский, Л.И.Думан, Ш.Сандаг, Н.Ц.Мункуев нартай хамтран бичжээ.

10 Шастина Н.П. Русско-монгольские посольские отношения ХУП века. М., 1958 – 175 с

11 Шастина Н.П. Монгольский сборник назидательных произведений. – Цэндийн Дамдинсүрэн. К 100-летию со дня рождения. Публикация А.Д.Цендиной. – М., 2008. – С. 236-249.

12 Шастина Н.П. Образ Чингисхана в средневековой литературе монголов – В кн.: Татаро-монголы в Азии и Европе. – М., 1970. – С.435-454.

Н.П.Шастина бол ХХ зуунд Зөвлөлтийн эрдэмтдийн Монголын түүх бичлэгийн судалгааг шинэ түвшинд гаргасан судлаач юм. Тэрбээр “БНМАУ-ын түүхийн судалгаа” (1952)¹³, “Октябрийн хувьсгалаас хойших Монголын түүхийн судалгаа” (1967) нийтлэлээ бичжээ¹⁴. “ЗСБНХУ дахь монгол шастир судлал” (1963)¹⁵, Оросын алдарт дорно дахин судлаачид болох монголч эрдэмтэн И.К.Рассохин, Н.Я.Бичурин, Д.Банзаров, О.М.Ковалевский, В.П.Васильев, А.М.Позднеев. Б.Я.Владимирцов, Г.Д.Санжеев нарын тухай олон өгүүлэл туурвиж, эх орон нэгтнүүдийнхээ бүтээл туурвилыг олонд таниулсан, өөрөө ч дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монголч эрдэмтэн болжээ¹⁶.

1953 онд Н.П.Шастина “XVII зууны төгсгөл үеийн монголчуудын түүхийн талаарх И.Рассохины орчуулга”¹⁷ гэсэн өгүүлэл нийтлүүлж, түүндээ Оросын анхны нанхиадач, манж судлаачийн гар бичмэлийг судалсны үр дүнгээ илтгэжээ. И.К.Рассохины гар бичмэл “История о завоевании китайским ханом Канхием калкаского и элетского

народа, кочующего в Великой Татарии, состоящая в пяти частях. Переведена с маньчжурского языка на российский прапорщиком Ларионом Рассохиным. 1750 г.) зохиол нь 3 боть бөгөөд Монголын түүх, Орос-Монголын болон Монгол Манжийн харилцааны түүхийг бичиж тэмдэглэсэн байв. Гар бичмэл зохиолыг уншиж судлах нь үлэмж хэмжээний цаг хугацаа шаардсан нүсэр ажил байсан аж. Тэдгээрийг судлаад дараах дүгнэлтэд тэрээр хүрчээ. Үүнд: “Энх Амгалан хаан болон Галдангийн хоорондын хэлэлцээр хэрхэн явагдсаныг илэрхийлэх маш олон баримтууд байгаа нь түүний ач холбогдлыг илэрхийлнэ. Мөн Цэвээнравдан болон Энх Амгалан хоёрын хоорондын хэлэлцээрийн талаар сонирхолтой эх сурвалжуудыг мөн агуулна. Түүнээс гадна Хөх нуурын монголчуудын талаар бага сага мэдээлэл байгаа нь мөн л ихээхэн үнэ цэнтэй. Эх сурвалжаас Манжийн элч нарыг шууд хууран мэхэлж, Галданд тусалж байсан Далай ламыг Энх Амгалан хаанаас нас барсныг нуухыг хүссэн төвөдийн ламтны бодлогын үнэн дүр төрхийг

13 Шастина Н.П. История изучения Монгольской Народной Республики. (Краткий очерк)// Монгольская Народная Республика. Сб. статей. – М.,1952. – С.15-55.

14 Шастина Н.П. Изучение истории Монголии после Октября – Народы Азии и Африки, 1967, №4. –С.6—74.

15 Шастина Н.П. Изучение монгольских летописей в СССР//XXVI Международный конгресс востоковедов. Доклады делегации СССР – М.,1963.- 12 с.

16 Шастина Н.П. Б.Я.Владимирцов //Российские монголоеды (ХУШ – начало ХХ в.). – Улан-Удэ, 1997. – С.141-145; Шастина Н.П. А.М.Позднеев. Подготовка к печати, примечания. А.Г.Сазыкина) //Mongolica – 6. – СПб, 2003. – С.7-18. Шастина Н.П. Из переписки О.М.Ковалевского с бурятскими друзьями. – В кн.: Материалы по истории и филологии Центральной Азии. – Улан-Удэ; Шастина Н.П. Профессору Г.Д.Санжееву – 70 лет. – Исследования по восточной филологии. К 70-летию проф. Г.Д.Санжеева. – М., 1977. – С.5-11; Шастина Н.П. Борис Яковлевич Владимирцов (1884-1931). – В кн.: Филология и история монгольских народов. Памяти акад. Б.Я.Владимирцова. – М., 1958. – С.3-11

17 Шастина Н.П. Перевод И.Рассохина по истории монголов конца ХVII в. – Ученые записки Института Востоковедения (АН СССР). Том 6, М.-Л.,1953. –С.200-211.

сэргээх боломжтой. Эх сурвалжийг нарийн ажиглан уншихад Манж нар Халхыг эзлэн түрэмгийлсэн үйл явцыг тодруулах боломж олгон өгч байгаа нь XVII зууны төгсгөл үеийн Монголын түүхийн тухайлсан хэрэг явдлуудын талаар мэдээлэл авах бололцоотой чухаг эх сурвалж болно” хэмээн баримтын ач холбогдлыг цохон тэмдэглэжээ¹⁸.

Н.П.Шастинагийн бичсэн “Оросын Монгол судлал дахь Н.Я.Бичурины бүтээлүүдийн ач холбогдол” (1956) нийтлэлд Н.Я.Бичурины Оросын шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг шинжлэн судлаад зогсохгүй, ХУШ-ХІХ зууны эхэн үеийн Оросын Монгол судлалын хөгжлийг илтгэн гаргажээ. Чингэхдээ Н.Я.Бичуринээс өмнөх үеийн Оросын Монгол судлалын хөгжилд мөн үнэлгээ, дүгнэлт мэргэжлийн төвшинд өгсөн байна. Тэр үед Оросын Монгол судлал шинжлэх ухааны чиглэл болон төлөвшиж байв. Тэр үеийн Оросын Монгол судлалын төвшнийг тэрээр ийнхүү үнэлэн цэгнэжээ: “Бичурины бүтээл гарахаас 100 жилийн өмнө Оросын шинжлэх ухааны сэтгэлгээнд монголчуудын талаар тодорхой мэдээлэл байсан хэдий ч ХІХ зууны 20-иод оны сүүл үед Монголын тухай мэдлэг тийм их арвин байгаагүй аж. Энэ нь эл салбарт судалгаа хийж байсан хүн байгаагүйтэй холбоотой байв. Эл үед тухайн ард түмний талаар зарим нэгэн түүхэн сурвалж болон газарзүйн мэдээлэл,

угсаатны зүйн хэрэглэгдэхүүн болох зан заншил, зан үйлийн талаарх зарим нэгэн мэдээлэл цуглуулж чадсан төвшинд л Монгол судлал оршиж байв” хэмээн бичжээ.¹⁹

Монголын тухай сахь эрдэмтний нийтлүүлсэн зохиол бүтээлүүдэд хоёр чиглэл тодорхой байдаг. Үүнд: монгол судлалын бүтээлүүд болон монгол судлалын чиглэлийн бус гэх. Үүнд, тухайлбал тодорхой сэдвийн хүрээнд монголчуудын түүхээс бичсэн судлаачид болох П.С.Паллас, И.Ф.Миллер, И.Г.Фишер, И.Г.Гмелин. Хоёрдох нь монгол хэл мэддэг, Монголын талаар асар их мэдлэгтэй боловч эрдмийн зэрэг хамгаалаагүй боловч ажлынхан шинж чанарыг нарийн ажиглавал Монгол судлалын асуудлуудын хөндөн бичсэн хүмүүс болох В.М.Бакунин, А.В.Игумнов, И.Я.Шмидт нар юм. Нина Павловна бүтээлдээ Бичурин-Клапрот, Бичурин-Шмидт нарын хоорондын шинжлэх ухааны маргаанд ихээхэн анхаарал хандуулсан байдаг. Түүний хэлснээр: “Бичурин Оросын Монгол судлалыг удаа дараа хамгаалж, гадаадын эрдэмтдийн, тэр дундаа Орост алба хашиж байгаа хүмүүсийн Оросын шинжлэх ухааны нэр төрийг гутаах оролдлогын эсрэг тэмцэж байсан” гэжээ²⁰.

Нина Павловна Шмидтээс Монгол судлалд оруулсан хувь нэмрийг дүгнэн бичихдээ нэн шүүмжлэлтэйгээр хандаж: “Шмидтийн ихэнх бүтээл

18 Шастина Н.П. Перевод И.Рассохина по истории монголов конца ХУШ в. – Ученые записки Института Востоковедения (АН СССР). Том 6, М.-Л., 1953. –С.-211.

19 Шастина Н.П. Значение трудов Н.Я.Бичурина // Очерки по истории русского востоковедения. – М., 1956. – С.182

20 Шастина Н.П. Значение трудов Н.Я.Бичурина // Очерки по истории русского востоковедения. – М., 1956. – С.194

цаг хугацааны хатуу үнэлгээг сөрж чадаагүй бөгөөд хоцрогдсон эсвэл шударгаар хэлбэл мартагдсан байдаг. Түүний орчуулсан Саган-Сэцэний феодалын алдарт шастир нь шүүмжлэлийг даахгүй. Түүний хэвлүүлсэн шастирын монгол бичвэр нь гажуудал, алдаануудаар дүүрэн байна” гэсэн байна²¹. Гэтэл өнөө буюу бидний үеийн монгол судлалын түүх болон дорно дахин судлаачид Шастинаагаас арай өөр дүгнэлт хийж: “Оросын Дорно дахин судлалын түүх” хамтын бүтээлдээ эрдэмтэн судлаачийн оруулсан хувь нэмрийг үнэлж, академич Шмидт дараагийн үеийн Орос дахь монголч эрдэмтдийн судалгааны эрэл хайгуулын цаашдын чиглэлийг үлэмж тодорхойлж өгч чадсан гэж бичсэн зүйл үзэгдэнэ..

Шастина Шмидтыг шууд бус боловч Оросын Дорно дахины судлаачдын эсрэг өөрсдийгөө тавьдаг германы дэг сургуулийн “харгис хэсгийн”-хэнтэй ойр хэмээн бичээд, түүнийг “Шмидт Монгол судлалын талаарх асуултуудыг зөвхөн тэр өөрөө л шийдэх эрхтэй гэж үзэж, Оросын Дорно дахины судлаачдыг үл тоомсорлосон хандлагыг илэн далангүй илэрхийлж байсан” хэмээжээ²². Хэдий тийнхүү Шмидтэд шүүмжлэлтэй хандаж байсан боловч түүнийг чадварлаг судлаач, монгол хэл маш сайн эзэмшсэн бөгөөд Монгол судлалын салбарт багагүй зүйл хийсэн. Монгол эх сурвалжуудыг шууд ашиглаж байсан нь Шмидтын

гавьяа бөгөөд түүний өмнө ихэнх бүтээлүүд нь монгол эх сурвалжуудын биечлэн үзэж уншиж тайлах бус харин хоёр, гурав дахь гараас олж авсан материал дээр үндэслэж байсан гэдгийг тэрээр цохон тэмдэглэжээ. Шмидтын бүтээлүүдэд Н.П.Шастинагийн хэлснээр бол “олон дутагдал, гажуудал, алдаа байдаг.” Түүний бүтээлд “асуулт тавих оролдлого болон тэдгээрийг шийдвэрлэх арга хэлбэрийн хувьд хязгаарлалт байдаг. Тэрээр эх сурвалжийн бичвэрт шүүмжлэлгүй хандсан байдаг тул Шмидтын бүтээлд болгоомжтой ашиглах хэрэгтэй” гэжээ²³.

Академич Шмидтийн судалгааны талаар шүүмжлэлтэй үгийг өмнө нь Д.Банзаров хэлж байв. Тэрээр Шмидтыг Чингисийн чулууны бичээсийг хэт “дураар орчуулсан” гэж зэмлээд, үгсийн сангийн өөрчлөлт, хэлний бүтэц, түүний түүхэн хувьсал өөрчлөлтийн талаар бичсэн байдаг. XX зууны 50-60-аад онд Г.И.Михайлов, Н.П.Шастина нар бүтээлээрээ дамжуулан И.Я.Шмидтэд хувь хүнийхэн хувьд болон түүний бүтээлүүдэд шүүмжлэлтэй хандах болж, түүнийг “дэвшилтэд эрдэмтэд” гэгдэх П.С.Савельев, В.В.Григорьев, О.М.Ковалевский нарт сөргүүлэн тавих болжээ. Хэл шинжээч Г.И.Михайлов монгол хэлний судлалд хандсан Шмидтын хандлагуудыг шүүмжилж, сахь эрдэмтэн монгол хэл болон индоевроп хэлний ижил төстэй зүйлийг хайж, улмаар индоевроп

21 Шастина Н.П. Эпиграфика в работах Доржи Банзарова // К столетию со дня смерти Доржи Банзарова.- Улан-Удэ, 1955. – С.51

22 Мөн тэнд

23 Мөн тэнд

хэлний хэм хэмжээнд монгол хэлийг тавьж үзэж байсан нь яавч тохирохгүй агаад зохисгүй хандлага байсан хэмээн шүүмжилсэн байна.

Н.П.Шастина “Монгол судлаач - В.П.Васильев” (1970г.) өгүүлэлдээ Монгол судлалын профессор О.М.Ковалевскийн шавь, хятад судлаач Васильевын эрдэм шинжилгээний бүтээлүүдийн талаар өгүүлжээ. Түүний бичсэнээр В.П.Васильев монгол судлалын талаар арван нэгэн бүтээл хэвлүүлж, арван гар бичмэл үлдээжээ²⁴. Тэрээр монгол хэлийг төгс эзэмшсэн, төрөлх хэл нь юм шиг ярьдаг байсан. Казанийн их сургуулийн төгсөлтийн ажлаа “Дух буддийского сочинения Хутухту Дэгэду Алтан Гэрэлту судур»” сэдвээр бичиж “Алтан гэрэлт” судрыг шинжлэн судалжээ. Мөн магистрын ажлаа “Буддын гүн ухааны үндэс суурийн тухай” сэдвээр хийсэн бөгөөд уг ажлынхан үндэс болсон буддын гүн ухааны зохиолуудыг нь О.М.Ковалевский Бээжин хотоос худалдан авсан байжээ²⁵. Н.П.Шастинагийн тэмдэглэсэнээр В.П.Васильев Оросын Монгол судлалд анх удаа хятад сурвалж бичигт үндэслэн “Төв Азийн дорнод хэсгийн эртний үе ба түүх” номоо бичиж, монголчууд ба киданчуудын хоорондох залгамж холбоог нээн тавьсан гэжээ. Тэрээр Киданы ард түмний түүхийг бусдаас илүү нарийвчлан судалж, уг ард түмний

угсаатны нийлэгжилт, кидан, зүрчид, монголчуудын түүхийг нарийвчлан судалж байжээ. В.П.Васильев анх удаа XIII зууны үеийн монголчуудын түүхэнд холбогдох хятад сурвалж болох “Мен-да бэй-лу”-г өвөрмөц түүхэн эх сурвалж хэмээн тодорхойлж судалсан бөгөөд хожим нь монголч эрдэмтэд болон нанхиадч нар олонтоо уг сурвалжийг ашигласан байдаг. В.П.Васильев нь Д.Банзаров болон Н.Я.Бичурины нэгэн адил “монгол” гэдэг үгийг тайлбарлахыг оролдсон юм. Н.П.Шастинагийн тэмдэглэсэнээр Васильевын дүгнэлт нь “...эрт дээр үед орчин үеийн Монголын нутаг дэвсгэр дээр амьдарч байсан овог аймгийн нэг нь “монгол” гэх нэртэй байсан агаад үүнийг хятад сурвалжууд ч гэрчилдэг” гэсэн аж. Энэ нь Монгол судлалд хүлээн зөвшөөрсөн байр суурьтай бүрэн нийцэж байгаа юм. Васильев цааш нь бусад овог аймгуудын нэгдлийн дараа нэгдмэл болж, монгол түмнийг тэмдэглэх нэршил болсон”²⁶ гэсэн байдаг.

Н.П.Шастина буриадын эрдэмтэн Дорж Банзаровоос Оросын Монгол судлалд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж, “Эпиграфика в работах Доржи Банзарова” (1955г.) өгүүллээ зориулжээ. Д.Банзаровын 15 бүтээлийн 5 нь бичээс судлалд зориулагдсан бөгөөд тэдгээр нь Монгол судлал бүрэлдэн тогтож байхад ихээхэн ач холбогдолтой зүйл байв. Шастина тус өгүүлэлдээ Аввакум Честный,

24 Шастина Н.П. В.П.Васильев как монголовед // Материалы по истории и филологии Центральной Азии. Выпуск 4. –Улан-Удэ, 1970. – С.12

25 Шастина Н.П. В.П.Васильев как монголовед // Материалы по истории и филологии Центральной Азии. Выпуск 4. –Улан-Удэ, 1970. – С.13

26 Шастина Н.П. В.П.Васильев как монголовед // Материалы по истории и филологии Центральной Азии. Выпуск 4. –Улан-Удэ, 1970. – С.16

В.В.Григорьев, И.Я.Шмидт нарын монгол бичээс судлалын маргааны талын асуудалд нэлээд анхаарал хандуулжээ. Н.В.Шастинагийн үзэж байгаагаар академич И.Я.Шмидтын В.В.Григорьев болон Аввакум нарын орчуулгад оруулсан залруулга, тайлбарын зарим нь зөв тохиромжтой байсан боловч, түүний хажуугаар буруу бөгөөд алдаатай зүйлс байсан.²⁷ Шмидт нь Шинжлэх ухааны академид тухайн үед ноёрхлоо тогтоогоод байсан герман хүмүүсийн нэг байсан бөгөөд оросын дорнодахин судлаачдыг үл тоомсорлодог нэгэн байсан бөгөөд Монгол судлалын асуудлыг тэр өөрөө ганцаараа шийдэх нэгэн гэж үзэж байв²⁸. Чингисийн чулууны бичээсийг Шмидт буруу тайлж уншсан агаад түүнийг зөв тайлж уншихын тулд Д.Банзаров 3 сар зарцуулсан, чингэхдээ Н.Бичурины орчуулгыг дэмжиж байв. Шастины онцлон тэмдэглэсэнээр, өнгөрсөн зууны 50-иад онд өмнө нь хэрэглэж байгаагүй арга болох түүхэн-хэл шинжлэлийн аргыг анх удаа хэрэглэсэн нь тоочин хүүрнэн өгүүлэх хэлбэрээс аналитик судалгааны аргыг анх удаа бүтээлчээр хэрэглэсэн хүн бол Банзаров байжээ. Түүний эртний бичээс судлалын ажлууд нь монголчуудын түүхийн асуудал болон монгол бичиг үсгийн түүхэнд холбогдоно²⁹.

Казанийн их сургуулийн дэд профессор А.С.Шофмантай хийсэн эрдэм шинжилгээний хэлэлцүүлэгт Н.П.Шастина: “Санкт-Петербургийн их сургуулийн шинжлэх ухааны үйл ажиллагаа Казанийн үе шатаас илүү үр дүнтэй байсан. Оросын тэргүүлэх дорно дахин судлаачид энд амжилттай ажиллаж байсан тул шинжлэх ухааны гол маргаан өрнөж, шинжлэх ухааны сэтгэлгээ хөгжсөн” гэж Монгол судлалын ууган төв Казаны их сургуулиас Петербургийнх илүү өндөр түвшинд хүрсэн гэдгийг цохон тэмдэглэсэн байна³⁰.

Н.П.Шастина Зөвлөлтийн 1920-1930-аад оны Монгол судлалын байдлыг “Монголын тухай дурсамжуудаас” (1971г.)³¹ гэх дургалдаа өгүүлжээ. Түүнд, Ж.Цэвээн, В.И.Лисовский, С.А.Кондратьев, А.Д.Симуков нарын тухай өгүүлсэн боловч энэхүү дурсамжид бичсэн зүйлүүдээс Нина Павловнагийн Монгол дахь амьдралыг нь бүрэн гаргах боломжгүй байгаа нь харамсалтай. Дурсамжид нь П.К.Козлов, Н.Н.Рерих нарын экспедицийн талаар мэдээлэл байхгүй, мөн түүнчлэн өөрөө хэрхэн монгол, төвд хэл сурсан, монгол судлаач болон хэрхэн төлөвшсөн зэргийн тухай өгүүлээгүй аж. Гэхдээ В.И.Лисовский, С.А.Кондратьев, А.Д.Симуков нарыг хувь хүнийхэн хувьд тодорхойлон

27 Шастина Н.П. Эпиграфика в работах Доржи Банзарова // К столетию со дня смерти Доржи Банзарова.- Улан-Удэ, 1955. – С.50

28 Шастина Н.П. Эпиграфика в работах Доржи Банзарова // К столетию со дня смерти Доржи Банзарова.- Улан-Удэ, 1955. – С.51

29 Шастина Н.П. Эпиграфика в работах Доржи Банзарова // К столетию со дня смерти Доржи Банзарова.- Улан-Удэ, 1955. – С.59

30 Шастина Н.П. Выступление кандидата исторических наук Н.П.Шастиной // К столетию со дня смерти Доржи Банзарова (Материалы научных сессий и статьи). – Улан-Удэ, 1955. – С.175-177.

31 Шастина Н.П. Из воспоминаний о Монголии//Книга братства. – М., -Улан-Батор, 1971. – С.196-208.

бичсэн зүйл их үнэ цэнтэй бөгөөд өнөө үед судалгааны эргэлтэд оруулах эзнээ хүлээн байгаа билээ.

Олон улсын Дорно дахин судлаачдын XXVI их хурал дээр Н.П.Шастинагийн тавьсан “ЗХУ дахь монгол шастир судлал” (1963г.) илтгэлд Зөвлөлт дахь 1930-1960-аад оны үед монгол болон буриад шастир судлалаар хийгдсэн ажилд үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Чингэхдээ энэ чиглэлээр Ж.Цэвээн, С.А.Козин, Б.И.Панкратов, Л.С.Пучковский, Г.Н.Румянцев, С.Д.Дылыков, З.Т.Тагаров нарын судалгааны өвд анхаарал хандуулж, улмаар эл чиглэлээр цаашид хийх судалгааны ажлын асуудлуудыг дэвшүүлэн тавьжээ.

Тэрбээр “БНМАУ-ын түүх” нэгэн боть хамтын бүтээл, “Оросын Дорно дахин судлалын түүх”-ийн зургаан цуврал (1953-1963г.), мөн түүнчлэн Плано Карпини болон В.Рубрукийн “Монголчуудын түүх”, “Дорно зүгийн орнуудаар яалсан нь” (1957г.) зэрэг зохиолуудын дахин хэвлэлтэд оролцсон юм. Түүний нэлээд бүтээлүүд нь гар бичмэлээрээ үлдэн амуй. Түүний “Эмгэнэл”-ийн бичигт Нина Павловна Оросын Монгол судлалын түүхээр шинжлэх ухааны докторын зэрэг горилох бүтээл бичиж байсан тухай бичсэн байсан. Түүний Монгол судлалын сэдвээр бичиж туурвисан бүтээлүүдийн жагсаалтыг харахад тэрээр хамгаалалтад бараг бэлэн байсан байх. Оросын монголч эрдэмтэд зориулсан өгүүлэл бүр нь шинжлэх

ухааны өвийг нь бие даасан байдлаар үнэлж, мөн монгол судлаачдын бие биетэйгээ хэрхэн уялдаа холбоотой болохыг харуулсан, дүгнэлт гаргалгаа нь дахин давтагдашгүй өөрийн гэсэн онцлогтой байдаг билээ. 80-90-ээд оны үед бусад зохиогчдын хэд хэдэн нийтлэл хэвлэгдэж байсан нь Н.П.Шастинагийн хэвлэн нийтлэх түвшинд хүрэхгүй нь тодорхой байв. Нина Павловнагийн бичсэн зарим гар бичмэлүүд Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн архивд хадгалагдаж байгаа боловч түүний докторын зэрэг горилсон бүтээлийн гар бичмэл хаа байгаа нь тодорхойгүй байна.

Шастинагийн зарим нэгэн судалгааны өгүүлүүд одоо хэвлэгдсээр байгаа нь түүний судалгааны гаргалгаа дүгнэлт ач холбогдлоо алдаагүй байгааг илтгэнэ. Жишээ нь: 1997 онд Улаан-Үд хотноо хэвлэгдэн гарсан “Оросын Монгол судлал (XVIII- XX зууны эхэн)” гэх хамтын бүтээлд Н.П.Шастины баримтууд дээр үндэслэн бичсэн, нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцовын тухай өгүүлэл оржээ³². Мөн 2003 онд Оросын хамгийн алдартай Монгол судлаач А.М.Позднеевын тухай өгүүлэл нь Санкт-Петербургт хэвлэгдэн гарчээ³³.

А.М.Позднеевыг Шастина Оросын нэрт Монгол судлаач хэмээн үнэлж: “Позднеев ер бусын хичээл зүтгэлээрээ бусдаас ялгарч, хэд хэдэн суурь бүтээл туурвисан бөгөөд нийт тоо нь 122 бөгөөд 400 хэвлэлийн хуудас. Үүний

32 Шастина Н.П. Б.Я.Владимирцов //Российские монголоеды (XVIII – начало XX в.). – Улан-Удэ, 1997. – С.141-145.

33 Шастина Н.П. А.М.Позднеев. Подготовка к печати, примечания. А.Г.Сазыкина) //Mongolica – 6. – СПб, 2003. – С.7-18.

17 нь нэгэн сэдэвт бүтээл. Тэрээр маш олон асуудлыг хөндөж судалгаа хийсэн. Нэмж дурдахад Позднеев боловсролын ажлыг сайн зохион байгуулагч байсан. Түүний эрч хүчтэй үйл ажиллагааны ачаар Дорно дахины хүрээлэн Владивостокт бий болж, түүний захирлаар хэдэн жилийн турш ажилласан юм”³⁴ хэмээн бичсэн амуй.

Монгол болон Зөвлөлтийн номын сангуудад удаан хугацааны туршид ажилласан нь түүх бичлэгийн сайн судлаач болгоход нь нөлөөлжээ. Мөн түүхэн эх сурвалж, түүхэн зохиол бүтээлтэй ажиллах арга барилд суралцахад нь ихээхэн түлхээс болсон гэлтэй. Гадаад ном зохиол уншин

тэмдэглэн авсан зүйлээ бичсэн хэд хэдэн дэвтэр хадгалагдан үлджээ. Хувьсгалын өмнөх Монгол судлалыг судлах нь Зөвлөлтийн үед төдийлөн таашаагдахгүй байсан тул хүнд суртлын дарамтад ч орж байжээ.

Н.П.Шастина Оросын сонгодог Монгол судлалыг цаашид хөгжүүлэн, харин түүний үйл хэргийн XX зууны 90-ээд оноос хойш ОХУ-ын судлаачдын шинэ үе нь үргэлжлүүлж байна. Н.П.Шастинагийн монгол судлалд оруулсан монголчуудын түүх болон эх сурвалж судлалын судалгаа нь өнөө үед Монголын түүх, түүх судлалыг тууштай судлах нэгэн холбоос болжээ.

Дүгнэлт

Н.П.Шастина монголч эрдэмтний өвөрмөц бүтээлч амьдралаар амьдарч байжээ. Тэрбээр Эрхүүгийн их сургуульд сонгодог либерал урлагийн боловсрол эзэмшсэн бөгөөд улмаар Москва, Санкт-Петербургийн нэрт эрдэмтэдтэй мөр зэрэгцэн ажиллаж байсан нь түүнийг бүтээлч хүн болгон төлөвшүүлжээ.

Монголд ажиллаж байсан 1924-1937 он, түүн дотроо 1929-1937 онуудад Судар бичгийн хүрээлэн, Шинжлэх ухааны хүрээлэнд ажилласан нь түүнд “жинхэнэ Монгол судлалын их сургууль” болжээ. Тэрээр монгол, төвд хэл сурч, ном судартай танилцаж, мөн тус оронд ажиллаж байсан Ц.Жамцарано, А.Симуков, В.Лисовский Н.К.Рерих, Ю.Н.Рерих,

П.К.Козлов нартай харилцаж, тэднээс суралцаж, дорнын хоёр дахь боловсрол эзэмшжээ. Шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сангийн Европ сангийн эрхлэгчээр 1931 оноос ажиллах үедээ тус салбараа орчин цагийн шинэ Номын сангийн хэмжээнд хүргэхэд ихээхэн идэвх санаачилгатай ажиллаж байжээ.

Монгол судлалаар эрдмийн зэрэг хамгаалж, шинжлэх ухааны байгууллага болон их сургуулиудад үр бүтээлтэй ажилласан түүний он жилүүд нь түүнийг хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн болгосон байна. Монголын түүх болон монголын түүхэн сурвалж бичиг судлал нь Н.П.Шастинагийн бүтээлч өвийн чухал хэсэг юм. Оросын шинжлэх

34 Шастина Н.П. А.М.Позднеев. Подготовка к печати, примечания. А.Г.Сазыкина) //Mongolica – 6. – СПб, 2003. – С.7.

ухааны түүхийг сайтар мэддэг судлаачийнхаа хувьд түүний түүх бичлэгийн бүтээлүүд нь Оросын Монгол судлалын түүхийг бие даасан байдлаар цогц харуулж чадсан агаад нэрт монголч эрдэмтдийн бүтээл туурвилд дүн шинжилгээ хийж чадсан амуй. Тэрээр Оросын Монгол судлаач Н.Я.Бичурен, А.В.Игумнова, Д.Банзаров нарын бүтээлүүдийг өндрөөр үнэлж, тэд Оросын шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэд гэж үзсэн байна. Түүний зэрэгцээгээр Оросын шинжлэх ухааны байгууллагад ажиллаж байсан герман гаралтай Монголч эрдэмтдийн бүтээлд шүүмжлэлтэй хандаж, тэднээс монгол судлалд оруулсан хувь нэмрийг хэт өндөрсгөн үзэх явдал байгаад шүүмжлэлттэй ханджээ.

Н.П.Шастиагийн хийсэн бүхий л судалгааны ажлын чанар, хэмжээ орчин

үеийн судлаачдыг гайхшируулдаг. Судалгааны өндөр соёл, эрдэмтний шинжлэх ухааны дүгнэлтийн үнэн зөв, няхуур чамбай байдал нь гүн хүндэтгэлийг хүлээх ажгуу.

Гагцхүү нэгэн харамсах зүйл бол тэрээр олон жилийн судалгааны ажлаа нэгтгэн дүгнэсэн докторын ажлаа хамгаалж чадаагүй явдал юм. Өдгөө ОХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнд хадгалагдаж буй Н.П.Шастиагийн гар бичмэлийн өвийг тусгайлан судлах нь зүйтэй гэж бид үзэж байна. Ингэснээр Орос дахь Монголын түүх судлалын судалгааны талаар илүү бүрэн дүүрэн дүр зураг гарах боломжтой. Чингээд эл талбарт, тухайлбал орчин үеийн Монгол судлалд эхний алхмууд хэдийнээ хийгдэж эхлээд байна³⁵.

Ашигласан материал:

1. Дашибалова Д.В. О работах Н.П.Шастиной в фондах ЦВРК ИМБТ СО РАН//Культура Центральной Азии: письменные памятники.- Улан-Удэ, 2019.- №12.- С.45-49. 35
2. Желтая история (Шара туджи). Пер. с монгольского, транслитерация, введ. и коммент. А.Д.Цендиной. – М., Наука – Вост. лит-ра, 2017.- 406 с.
3. Кузьмин Ю.В. 95-летие со дня рождения Н.П.Шастиной// Billetin International Association for Mongol Studies. –Ulaanbaatar, 1993. -№2(12). – С.89.
4. Кузьмин Ю.В. Нина Павловна Шастина – исследовательница Монголии // Тальцы. – Иркутск, 2002. №1(13). – С.22-26.
5. Кузьмин Ю.В. Монголоведные исследования Н.П.Шастиной// Россия и Восток: взгляд из Сибири на нач. тыс. Материалы межд.конф. –Иркутск, 2002. – С.135-139.

35 Дашибалова Д.В. О работах Н.П.Шастиной в фондах ЦВРК ИМБТ СО РАН//Культура Центральной Азии: письменные памятники.- Улан-Удэ, 2019.- №12.- С.45-49.; Желтая история (Шара туджи). Пер. с монгольского, транслитерация, введ. и коммент. А.Д.Цендиной. – М., Наука – Вост. лит-ра, 2017.- 406 с.

6. Шастина Н.П. «ЦАМ» (праздник в ламайских монастырях Монголии). – Хозяйство Монголии, 1928, №4(11). – С.79-83
7. Шастина Н.П. Цохчин в праздничные дни. – Хозяйство Монголии, 1928, №4(11). –С.79-83.
8. Шастина Н.П. Религиозная мистерия “цам” в монастыре Дзун-хуре // Современная Монголия, 1935, № 1. №4(11).
9. Шастина Н.П. Круговращение Майдари. – Современная Монголия, 1935, №5. С.106-107
10. Шастина Н.П. Русско-монгольские посольские отношения XVII века. М., 1958 – 175 с.
11. Шастина Н.П. Значение трудов Н.Я.Бичурина // Очерки по истории русского востоковедения. – М., 1956. – С.182
12. Шастина Н.П. Эпиграфика в работах Доржи Банзарова // К столетию со дня смерти Доржи Банзарова.- Улан-Удэ, 1955. – С.51
13. Шастина Н.П. Б.Я.Владимирцов //Российские монголоеды (XVIII – начало XX в.). – Улан-Удэ, 1997. – С.141-145.
14. Шастина Н.П. А.М.Позднеев. Подготовка к печати, примечания. А.Г.Сазыкина) //Mongolica – 6. – СПб, 2003. – С.7-18.
15. Шастина Н.П. История изучения Монгольской Народной Республики. (Краткий очерк)// Монгольская Народная Республика. Сб. статей. – М.,1952. – С.15-55.
16. Шастина Н.П. Изучение монгольских летописей в СССР//XXVI Международный конгресс востоковедов. Доклады делегации СССР – М.,1963.- 12 с.
17. Шастина Н.П. Перевод И.Рассохина по истории монголов конца XVII в. – Ученые записки Института Востоковедения (АН СССР). Том 6, М.-Л.,1953. –С.200-211.
18. Шастина Н.П. Выступление кандидата исторических наук Н.П.Шастиной // К столетию со дня смерти Доржи Банзарова (Материалы научных сессий и статьи). – Улан-Удэ, 1955. – С.175-177.
19. Шастина Н.П. Из переписки О.М.Ковалевского с бурятскими друзьями. – В кн.: Материалы по истории и филологии Центральной Азии. – Улан-Удэ,
20. Шастина Н.П. Изучение истории Монголии после Октября – Народы Азии и Африки, 1967, №4. –С.6—74.
21. Шастина Н.П. Образ Чингисхана в средневековой литературе монголов – В кн.: Татаро-монголы в Азии и Европе. – М.,1970. –С.435-454.
22. Шастина Н.П. В.П.Васильев как монголовед // Материалы по истории и филологии Центральной Азии. Выпуск 4. –Улан-Удэ, 1970. – С.12 –17.

23. Шастина Н.П. Повесть о споре мальчика-сироты с девятью витязями Чингисхана. – В кн.: Страны и народы Востока. Вып.Х1. М., 1971,-С.127-139.
24. Шастина Н.П. Из воспоминаний о Монголии//Книга братства. – М., -Улан-Батор, 1971. – С.196-208.
25. Шастина Н.П. Профессору Г.Д.Санжееву – 70 лет. – Исследования по восточной филологии. К 70-летию проф. Г.Д.Санжеева. – М., 1977. – С.5-11.
26. Шастина Н.П. Борис Яковлевич Владимирцов (1884-1931). – В кн.: Филология и история монгольских народов. Памяти акад. Б.Я.Владимирцова. – М., 1958. – С.3-11
27. Шастина Н.П. Монгольский сборник назидательных произведений. – Цэндийн Дамдинсурэн. К 100-летию со дня рождения. Публикация А.Д.Цендиной. – М., 2008. – С. 236-249.
28. Яцковская К.Н. Неопубликованные материалы 20-х годов из личного архива Н.П.Шастиной (1898-1980) //Mongolika - Ш. Из архивов отечественных монголоведов XIX - начало XX вв.- Санкт-Петербург, 1994.-С.23-25.
29. Яцковская К.Н. Моя Монголия (вторая половина XX века).- М.: Изд-во «Спутник+», 2011.- 344 с.
30. Л.Энхбаатар. Дөрвөн үеэрээ Монголд зүтгэсэн орос эмчийн гэр бүл. https://www.tolgoilogch.mn/_vh-vkhsz88
31. УТА, Ф-23, д.1, хн 312. Н.П.Шастинагийн ажлын төлөвлөгөө 1932, 1933 он
32. УТА, Ф-23, д.1, хн 243, хуудас 3-7 Анкет, 1929 он
33. УТА, Ф-23, д.1, хн 303, хуудас 1-8 Анкет, 1632 он

Mongolist scholar N.P.Shastina

U.V.Kuzmin*

*Professor, Sc.D in History, Baikal State University of Russia, Irkutsk, Russia
kuzminuv@yandex.ru*

Urangua Jamsran

*Professor, Sc.D History, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia
Urangua@num.edu.mn*

Abstract: *The article presents the biography of N. P. Shastina (1898-1980), a well-known researcher of the history and historiography of Mongolia and Russian-Mongolian relations. The main attention is paid to the works of N. P. Shastina devoted to the history of Russian-Mongolian studies, works of the leading Mongolian scholars of the country. Her contribution to the study of the history of Russian Mongolian studies and Russian science of the XIX century is shown.*

Keywords: *N. P. Shastina, Russian Mongolian studies, historiography, history of science, Mongolia, biographies.*

<i>The day of submission:</i>	2021.04.20
<i>Completion of review:</i>	2021.06.08
<i>Final decision for acceptance:</i>	2021.06.10

* Corresponding author